



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/233

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Нийтийн биеийн тамирын талбай байгуулах (Булган сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Бурхууд” ХХК-тай 485 611 561 (Дөрвөн зуун наян таван сая зургаан зуун арван нэгэн мянга таван зуун жаран нэг) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Бурхууд” ХХК-ийн захирал (Т.Болдбаатар)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010206

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 сарын
10 өдрийн 123 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	7 590 571	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	7 590 571	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	3 795 286	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	15 000 000	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн
7	Орон нутгаас авч ажиллах иргэдийн тоо	10 хүн	Н.Батжаргал